

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

**Компанийн жилийн үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг дүгнэх тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 24 дүгээр зүйлийн 24.3, “Грант Торнтон Аудит” ХХК-ийн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хараат бус аудиторын дүгнэлт, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг “Хангалттай сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд аудит хийсэн хараат бус аудитын өгсөн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2021 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах, компанийн хуримтлагдсан ашгаас 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн ногдол ашиг хуваарилж, үүнээс 3,385,000,000 (гурван тэрбум гурван зуун наян таван сая) төгрөгөөр Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан “Давхар даатгалын компанийн сан” болон бусад нөхөн төлбөрийн нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, 1,115,000,000 (нэг тэрбум нэг зуун арван таван сая) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх саналыг Хувьцаа эзэмшигчид уламжилж чиглэл авахаар тогтсугай

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Б.Шаравсамбуу)-д үүрэг болгосугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД